

ДУНДГОВЬ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТСИЙН ТАЙЛАН

2023 оны 09 сарын 18




Сайнцагаан сум

Авлигатай тэмцэх жилийн хүрээнд өрнүүлсэн соён гэгээрүүлэх аянд нэгдсэн тухай

Монгол улсын Засгийн газрын 2023 оны 49-р тогтоолоор 2023-2024 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон зарласантай холбогдуулан Авлигатай тэмцэх газраас авлигын эсрэг үйл хэрэгт иргэн бүрийн оролцоог хангах зорилгоор 5 сарын 29-ний өдрөөс улс орон даяар соён гэгээрүүлэх аян өрнүүлж байгаа билээ. Тус хэлтсээс аяны хүрээнд дараах ажлыг зохион байгууллаа.

1. Авлигатай тэмцэх газраас бэлтгэн ирүүлсэн материалыг дараах байдлаар олон нийтэд түгээсэн байна

- 2 төрлийн постерийг хэлтсийн мэдээллийн самбарт байршуулав
- Хэлтсийн цахим хуудсанд аяны талаар мэдээлэл оруулж, иргэд олон нийтийг шүгэл үлээхийг уриаллаа.
- Хэлтсийн пэйж хуудсанд 1 видео шторк, 7 өөр постер бүхий 4 пост оруулсан мөн АТГ-аас өгсөн чиглэлийн дагуу пэйж хуудасны ковер зургийг “Нэгдэе” аяны зургаар солиод байна.



2. Төрийн үйлчилгээний хүнд суртал, чирэгдлийг багасгах хүрээнд байгууллагын ил тод нээлттэй байдлыг хангахаар хэлтсийн сайтад Статистик мэдээллийг хэрэглэгчид хэрэглэхэд амар байдлаар бэлдэж байршууллаа.

ТАЙЛАН БИЧСЭН: С.ДОРЖХАНД

ТАЙЛАН ХЯНАСАН:
ДАРГА Б.ЭНХТУЯА